



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/175

Булган

Гэрээ шууд байгуулах эрх
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” төсөл, арга хэмжээний зардлаас Орхон сумын Засаг дарга /С.Бат-Эрдэнэ/-д 5 000 000 /таван сая/ төгрөгийн эрх шилжүүлсүгэй.

2. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх ажлын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа хийх” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Эрх шилжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу зохион байгуулж, гэрээ байгуулан гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Орхон сумын Засаг дарга /С.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190174